МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 20 өдөр Дугаар А/104 Мөрөн сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.6, Монгол Улсын Засгийн 2021 оны 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн бага төвөгшилтэй барилга байгууламж, барилга, байгууламжийн гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга:
Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Комиссын гишүүд:
Захиалагч байгууллагын төлөөлөл
Аймгийн Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл
Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төвийн төлөөлөл
Холбогдох хяналтын улсын байцаагч
Инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл
Архивын байгууллагын төлөөлөл
Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл
Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл
Зураг төслийн байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн бага төвөгшилтэй барилга байгууламж, барилга байгууламжийн гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг улирал тутамд танилцуулж ажиллахыг Комиссын дарга (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)-д даалгасугай.

3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн бага төвөгшилтэй барилга байгууламж, барилга байгууламжийн гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлын үр ашгийг дээшлүүлэн, барилга байгууламжийн хувийн хэрэгт баяжилт, бүртгэл хийж ажиллахыг ашиглагч байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

6712010455

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны А/623 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН